

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2024/111/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын өргөө, Тэр баян Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70597208. Цахым хаяг: dundgoviaudit.gov.mn

2024-02-06 № 09

Тайлан № _____

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ- УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Н.ӨЛЗИЙТГОГТОХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Завсрын аудитаар өгсөн хөрөнгийн тооллогыг чанартай хийж тооцоог бодож, баталгаажуулах, бараа материалын хөдөлгөөнийг агуулахын бүртгэлээр хөтөлж, тооцоо бодон, баталгаажуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, жилийн эцсийн аудитаар санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн дүн 56,359.6 мянган төгрөгөөр, бараа материалын дүн 4,973.2 төгрөгөөр тооллогын бүртгэл зөрүүтэй, тооцоог бодож, баталгаажуулаагүй, мөн 2023 онд байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа 4 авто машинд зарцуулсан шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог бодож баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/ тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т /анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаалын 1-р хавсралтыг тус тус зөрчсөн байна. Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 1.0 сая төгрөгөөр бага боловч, санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн дүн 56,359.6 мянган төгрөгөөр, бараа материалын дүн 4,973.2 төгрөгөөр тооллогын бүртгэлээс зөрүүтэй, тооцоог бодож, баталгаажуулаагүй, шатахууны зардлыг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог тооцоог бодож баталгаажуулаагүй зэрэг зөрчил нь шинж чанар агуулгын хувьд материаллаг, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд: 0020240020

Үндсэн хөрөнгө 440.0 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүнээс 29.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 396.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан;

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 152 дугаар тогтоолоор Ган-Илч ХХК-ны дулааны эрчим хүчний үнэ тарифыг нэмж баталснаас 1.6 сая төгрөгийн халаалтын өглөг үүссэн;

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.5 дахин өссөн. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дотоод хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг байгууллагын даргын 2023 оны А/86 дугаар тушаалаар шинэчлэн баталсан боловч байгууллагын үйл ажиллагаанд огт хяналт шалгалт хэрэгжүүлээгүй, төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нар нь төсөв санхүүд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан асуудал нь нөлөө бүхий эрсдэлтэй асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, 73 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, Говь-Угтаал сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 90.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэгжүүлэх үүрэг бүхий шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР МОНХТОГТОХ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>82,768,992.47</u>	<u>94,330,966.07</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	9,354,795.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	9,354,795.00
3121	Төгрөг	-	9,354,795.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	9,354,795.00
33	АВЛАГА	14,489,561.00	15,424,594.00
335	Бусад авлага	14,489,561.00	15,424,594.00
3351	Байгууллагаас авах авлага	-	935,033.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	14,489,561.00	14,489,561.00
35	БАРАА МАТЕРИАЛ	62,279,431.47	69,551,577.07
351	Түүхий эд материал	8,000,000.00	8,000,000.00
35110	Тусгай зориулалттай материал	8,000,000.00	8,000,000.00
354	Хангамжийн материал	60,279,431.47	61,551,577.07
35410	Бичиг хэргийн материал	2,352,700.00	2,929,000.00
35420	Аж ахуйн материал	57,286,681.47	53,984,877.07
35440	Түлш, шатах тослох материал	640,050.00	4,637,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,247,352,604.61</u>	<u>1,595,367,957.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,247,352,604.61	1,595,367,957.03
392	Биет хөрөнгө	1,225,069,104.69	1,568,749,331.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,246,010,179.83	1,353,127,830.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(218,862,098.74)	(271,429,829.17)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	124,964,800.00	300,306,950.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(82,655,611.04)	(62,789,186.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	158,873,969.00	246,958,070.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(44,185,302.70)	(42,838,380.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,844,212.57	56,521,250.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,145,554.31)	(13,912,045.75)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	750,000.04	750,000.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,124,184.60	4,574,184.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,649,674.56)	(2,519,511.48)
393	Биет бус хөрөнгө	22,283,499.92	26,618,625.12
39301	Програм хангамж	2,070,000.00	6,856,625.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,310,500.08)	(1,761,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	21,524,000.00	21,524,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,330,121,597.08</u>	<u>1,689,698,923.10</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		<u>1,631,899.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,631,899.00
413	Өглөг	-	1,631,899.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,631,899.00

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,330,121,597.08</u>	<u>1,688,067,024.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,330,121,597.08	1,688,067,024.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	462,149,763.67	462,149,763.67
51101	Өмч: - төрийн	462,149,763.67	462,149,763.67
512	Хуримтлагдсан үр дүн	652,437,970.44	974,486,471.50
51210	Өмнөх үеийн үр дүн	652,437,970.44	652,437,970.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	322,048,501.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	215,533,862.97	251,430,788.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,330,121,597.08</u>	<u>1,689,698,923.10</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	510,670,122.00	1,004,108,689.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	135,306,022.00	427,044,554.00
120	Нийтлэг татварын бус орлого	135,306,022.00	427,044,554.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	135,306,022.00	16,661,195.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,844,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	135,306,022.00	
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		6,816,695.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- үндсэн хөрөнгө		410,383,359.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	375,364,100.00	577,064,135.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	25,879,335.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,885,707.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	19,993,628.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	375,364,100.00	551,184,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	375,364,100.00	551,184,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	495,330,746.44	676,006,138.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	495,330,746.44	676,006,138.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387,507,452.44	551,074,300.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,931,071.00	251,108,895.00
210101	Үндсэн цалин	137,084,138.00	192,804,389.00
210102	Нэмэгдэл	22,831,472.00	41,222,504.00
210104	Урамшуулал	10,015,461.00	17,082,002.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,180,349.00	29,962,015.00
210201	Тэтгэврийн даатгал	15,073,044.00	21,414,069.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,773,292.00	2,582,123.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,364,870.00	2,017,129.00

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	262,697.00	355,997.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,706,446.00	3,592,697.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,097,056.00	31,096,152.51
210301	Гэрэл, цахилгаан	4,251,616.00	5,355,014.51
210302	Түлш, халаалт	20,845,440.00	25,741,138.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,571,810.00	39,977,534.40
210401	Бичиг хэрэг	2,477,000.00	4,356,500.00
210402	Тээвэр, шатахуун	12,384,184.00	18,013,680.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,361,633.00	2,503,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,652,350.00	3,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,531,400.00	11,603,554.40
210408	Бараа материал акталсны зардал	1,165,243.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,477,800.00	15,285,000.00
210604	Урсгал засвар	6,477,800.00	15,285,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,266,000.00	18,912,000.00
210702	Дотоод албан томилолт	8,266,000.00	18,912,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,672,748.00	8,325,294.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,590,000.00	7,658,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,975.00	103,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,821.00	260,216.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	-
210807	Газрын төлбөр	225,952.00	226,028.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,310,618.44	156,407,409.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,903,104.00	33,616,526.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	790,000.00	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,617,514.44	121,790,883.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,823,294.00	124,931,838.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,439,750.00	16,024,800.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,500,000.00	7,800,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,453,250.00	6,317,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,874,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	612,000.00	1,907,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	83,383,544.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	83,383,544.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	108,907,038.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	108,907,038.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	15,339,375.56	328,102,550.07
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,422,803.45	6,054,049.01
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,422,803.45	6,054,049.01
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,422,803.45)	(6,054,049.01)

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>13,916,572.11</u>	<u>322,048,501.06</u>
---	-------------------------	----------------------	-----------------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>375,364,100.00</u>	<u>593,725,330.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	16,661,195.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	16,661,195.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	16,661,195.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,844,500.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		6,816,695.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	375,364,100.00	577,064,135.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	25,879,335.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,885,707.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	19,993,628.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	375,364,100.00	551,184,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	375,364,100.00	551,184,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>404,553,145.00</u>	<u>554,790,535.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	404,553,145.00	554,790,535.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	296,729,851.00	429,858,696.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,931,071.00	251,471,911.00
210101	Үндсэн цалин	137,084,138.00	193,167,405.00
210102	Нэмэгдэл	22,831,472.00	41,222,504.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	10,015,461.00	17,082,002.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,180,349.00	30,534,032.00
210201	Тэтгэврийн даатгал	15,073,044.00	21,986,086.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,773,292.00	2,582,123.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,364,870.00	2,017,129.00
210204	Ажилгүйдлийн даатгал	262,697.00	355,997.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,706,446.00	3,592,697.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,367,056.00	29,464,253.51
210301	Гэрэл, цахилгаан	4,521,616.00	5,355,014.51
210302	Түлш, халаалт	20,845,440.00	24,109,239.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,801,533.00	29,665,280.00
210401	Бичиг хэрэг	3,203,750.00	3,032,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,015,400.00	19,016,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,361,633.00	2,503,800.00

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,652,350.00	3,829,180.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,568,400.00	1,283,800.00
2105	Нормативт зардал	-	308,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	308,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,790,800.00	17,174,400.00
210604	Урсгал засвар	8,790,800.00	17,174,400.00
2107	Томилолт, зочны зардал	8,266,000.00	18,912,000.00
210702	Дотоод албан томиллолт	8,266,000.00	18,912,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,672,748.00	8,503,294.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,590,000.00	7,658,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	150,975.00	103,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,821.00	260,216.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	178,000.00
210807	Газрын төлбөр	225,952.00	226,028.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,720,294.00	43,825,526.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,930,294.00	42,488,026.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	790,000.00	1,337,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,823,294.00	124,931,838.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,439,750.00	16,024,800.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,500,000.00	7,800,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,453,250.00	6,317,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,874,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	612,000.00	1,907,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	83,383,544.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	83,383,544.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	108,907,038.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	108,907,038.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(29,189,045.00)</u>	<u>38,934,795.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,080,000.00	29,580,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,080,000.00	29,580,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,080,000.00	29,580,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,080,000.00	29,580,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(16,080,000.00)</u>	<u>(29,580,000.00)</u>

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(45,269,045.00)	9,354,795.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,354,795.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	462,149,763.67	215,533,862.97	593,522,353.33	1,271,205,979.97
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	462,149,763.67	215,533,862.97	593,522,353.33	1,271,205,979.97
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	58,915,617.11	58,915,617.11
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	462,149,763.67	215,533,862.97	652,437,970.44	1,330,121,597.08
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	462,149,763.67	215,533,862.97	652,437,970.44	1,330,121,597.08
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	462,149,763.67	215,533,862.97	652,437,970.44	1,330,121,597.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	35,896,925.96	-	35,896,925.96
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	322,048,501.06	322,048,501.06
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	462,149,763.67	251,430,788.93	974,486,471.50	1,688,067,024.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	553,184,800.00	457,885,846.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528,184,800.00	457,885,846.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	511,264,800.00	441,861,046.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	262,792,200.00	251,471,911.00
210101	Үндсэн цалин	202,401,800.00	193,167,405.00
210102	Нэмэгдэл	47,345,400.00	41,222,504.00
210104	Урамшуулал	13,045,000.00	17,082,002.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,206,000.00	30,534,032.00
210201	Тэтгэврийн даатгал	23,664,000.00	21,986,086.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,780,400.00	2,582,123.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,188,400.00	2,017,129.00

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	452,100.00	355,997.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,121,100.00	3,592,697.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,746,600.00	28,395,173.38
210301	Гэрэл, цахилгаан	4,600,000.00	4,285,934.38
210302	Түлш, халаалт	24,146,600.00	24,109,239.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,817,000.00	28,612,410.00
210401	Бичиг хэрэг	3,100,000.00	3,032,500.00
210402	Тээвэр, шатахуун	18,287,000.00	18,278,130.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,230,000.00	2,188,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,900,000.00	3,829,180.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	1,283,800.00
2105	Нормативт зардал	650,000.00	308,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	650,000.00	308,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,520,000.00	37,654,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,380,000.00	21,580,000.00
210604	Урсгал засвар	16,140,000.00	16,074,400.00
2107	Томилолт, зочны зардал	21,940,000.00	17,832,000.00
210702	Дотоод албан томилолт	21,940,000.00	17,832,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,253,000.00	4,203,494.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,076,000.00	3,358,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	684,000.00	103,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	373,000.00	260,216.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	148,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	178,000.00
210807	Газрын төлбөр	372,000.00	226,028.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,340,000.00	42,849,626.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,000,000.00	41,512,126.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,340,000.00	1,337,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,920,000.00	16,024,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,920,000.00	16,024,800.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7,800,000.00	7,800,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,750,000.00	6,317,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,370,000.00	1,907,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,000,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	25,000,000.00	-
223001	Бусад хөрөнгө	25,000,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	553,184,800.00	457,885,846.38
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	551,184,800.00	455,841,346.38
132001	Орон нутгийн төсвөөс	551,184,800.00	455,841,346.38
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	2,044,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	2,044,500.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-
---	---	---

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,879,335.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,879,335.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,315,750.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,069,080.13
210301	Гэрэл, цахилгаан	1,069,080.13
2104	Хангамж, бараа материалын зардал	1,052,870.00
210402	Тээвэр, шатахуун	737,870.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	315,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,080,000.00
210702	Дотоод албан томилолт	1,080,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,299,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,299,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	714,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	714,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,563,584.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,563,584.87
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,563,584.87
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,879,335.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,879,335.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,885,707.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,993,628.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **38,624.9** мянган төгрөгийн зөрчил илрүүлэн аудитын явцад **3,632.4** мянган төгрөгийн алдааг залруулж, **1,501.5** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **33,491.0** мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлагыг тус тус хүргүүлсэн.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 3,632.4 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Үр дүнгийн тайланд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг зөрүүтэй тайлагнасан.
2. Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг зөрүүтэй тайлагнасан.
3. Халаалтын зардлын өглөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 34,992.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1,501.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 33,491.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлэх асуудалтай холбоотой зөрчлийг арилгуулах 9 албан шаардлага хүргүүлсэн.

3.1. Төлбөрийн акт

1. Орон сууцны түрээсийн орлогыг **1,501,500.00** /Нэг сая таван зуун нэг мянга таван зуун/ төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.1/ *өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах*/, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” 2020 оны 08 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Орон нутгийн өөрийн өмчийн гэрээний үлгэрчилсэн загвар”- ын дагуу түрээслэгчтэй байгуулсан 01-7 дугаартай гэрээний 3.4- т /Түрээслэгч нь түрээсийн сарын төлбөр болох.....(тоо, үсгээр бичих) төгрөгийг тухайн сарын 25-ны өдрийн дотор түрээслүүлэгчийн дансанд шилжүүлнэ./, 5.11.-т /Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлөөгүй бол энэхүү гэрээнд заасан алданги ногдуулж, төлүүлэх эрхтэй./ 6.8.-д /Түрээсийн төлбөр болон ашиглалтын зардлыг энэхүү гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй./ заасныг тус тус зөрчсөн байна.

3.2. Албан шаардлага

1. Аудитаар бараа материалыг шаардах хуудсаар олгоогүй, агуулахын бүртгэлийг хөтлөөгүйгээс бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*/, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “*Маягт, заавар батлах тухай*” зааврын 5.-д /*Бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг тухай бүрд мэдэх, түүний бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор агуулахын бүртгэлийг эд хариуцагч материалын нэр төрөл, зэрэг, дугаар бүр дээр нээж хөтөлнө.*/, 6-д /*Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн "Шаардах хуудас"-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ.* / заасныг тус тус зөрчсөн;

2. 2022 онд хандив тусламжаар ирсэн “**Ноос прэслэгч машин**” болон “**Ноос хяргах цахилгаан хайч**”-ыг орлого авч бүртгэл тайланд тусгаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 –д /*Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ.*/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д /*Нягтлан бодох*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, 14.4.2.-т /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;/, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолын “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2 –т /Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, акталж данснаас хасах, худалдах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Орон нутгийн өмчийн газарт тавьж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ/, 4.8-д /Улс болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг тухайн орон нутгийн өмчит байгууллага ашиглаж байгаа боловч данс бүртгэлд тусгаагүй бол түүнийг зөрчил гэж үзэх бөгөөд тэдгээр хөрөнгийг данс бүртгэлд тусгах асуудлыг Орон нутгийн өмчийн газарт нэн даруй тавьж шийдвэрлүүлнэ/ заасныг тус тус зөрчсөн;

3. Ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа “Эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл” хөтлөөгүй, албан хаагчидтай “Эд хөрөнгийн бүрэн хариуцлага”-ын гэрээг байгуулаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 /Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна./, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т /Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ/, Хөдөлмөрийн тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.3-т /Ажил олгогч нь эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэж болох ажил, албан тушаалын жагсаалтын дагуу ажилтантай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай гэрээ байгуулна/, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “*Маягт, заавар батлах тухай*” зааврын 10.-д /Аж ахуйн нэгж, байгууллагын ажилчин, албан хаагчдын албан хэрэгцээнд эзэмшиж байгаа эд хөрөнгийг нэр төрлөөр ангилан бүртгэж, уг бүртгэлийг тооллогын комисс 3 хувь үйлдэж, 1 дүгээр хувийг санхүүгийн албанд, 2 дугаар хувийг аж ахуйн эрхлэгч (нярав)-д, үлдэх хувийг эд хариуцагчид өгнө. Ажилчин, албан хаагчдын хэрэгцээнд ашиглагдаж байгаа эд хөрөнгийн бэлэн байгаа үлдэгдлийг тооллогын комисс үзэж биечлэн тоолоод тооллого явуулсан хугацааг тодорхой заан тооллогын бүртгэлд гарын үсэг зурна./, тус тус зөрчсөн;

4. Хагас жилийн хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоог бодож баталгаажуулаагүй, байгууллагын эд хариуцагч солигдсон боловч хөрөнгө, өр төлбөр тооцооны тооллогыг хийгээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д /өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;/, 70 дугаар зүйлийн 70.2-т /Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т /12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:/, 12.2.2.-т /Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:/, 20 дугаар зүйлийн 20.2.6-т /Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн;

5. Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа 4 авто машинд зарцуулсан **4,082,500.00** /Дөрвөн сая наян хоёр мянга таван зуун/ төгрөгийн тээвэр шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй. /2023 оны албан хэрэгцээнд ашиглаж байгаа авто машины тооцоог огт бодоогүй, шатахууныг нормоор олгож байгаа эсэхэд хяналт огт тавиагүй/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. /Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат, дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна/, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-р хавсралт /Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг үндэслэн тогтоож, мөрдөж ажиллах, шатахууны

зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актыг үйлдэж баталгаажуулах/ дахь заалтыг тус тус зөрчсөн;

6. Цалингийн зардлаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал **92,422.00** /Ерөн хоёр мянга дөрвөн зуун хорин хоёр/ төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т */Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/*, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т **“Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл”** */Ажил олгогчоос тайлант жилийн хугацаанд Нийгмийн даатгалын тухай болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр үндсэн болон нэмэгдэл цалин, түүнтэй адилтгах орлогоос албан журмаар төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тооцож энэ ангилалд бүртгэнэ. Эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянаж болно/* заасныг тус тус зөрчсөн;

7. Тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийхдээ тухайн бараа нь цахим дэлгүүрт байршсан эсэхэд судалгаа хийлгүй цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс **29,280,000.00** */Хорин есөн сая хоёр зуун наян мянган/* төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.13. */Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно./*, 48 дугаар зүйлийн 48.5. */Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ./* Төрийн хэмнэлтийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4. */Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно/* заасныг;

8. Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч У.Сүнжидмаа нь өмнөх аудитаар өгөгдсөн зөрчил арилгуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулалт болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой зөрчлийг давтан гаргаж хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй. Үүнд:

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын явцад хяналт тавиагүй, тооцоог бодож баталгаажуулаагүй, тооллогын бүртгэлээрх хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд дахь хөрөнгийн үлдэгдлээс зөрүүтэй тайлагнасан. *(Энэхүү зөрчил нь 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар илэрч албан шаардлага хүргүүлсэн.)*
- Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 147.1 сая төгрөгийн зарлагын 11 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 75.1 сая төгрөгийн 32 шийдвэрийг мэдээлээгүй байна. *(Энэхүү зөрчил нь 2022 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар илэрч албан шаардлага хүргүүлсэн.)*

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 70 дугаар зүйлийн 70.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.2, 20 дугаар зүйлийн 20.2.6, болон Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6.4.5, 6.4.8, 7.2 - дахь заалтуудыг тус тус зөрчсөн;

9. Аудитаар Засаг даргын Тамгын газрын дарга Н.Өлзийтогтох, нягтлан бодогч У.Сүнжидмаа нь өмнөх аудитаар өгөгдсөн зөрчил арилгуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулалттай холбоотой зөрчлийг давтан гаргаж хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 147.1 сая төгрөгийн зарлагын 11 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 75.1 сая төгрөгийн 32 шийдвэрийг мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 56.1 хувьтай. *(Энэхүү зөрчил нь 2022 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар илэрч албан шаардлага хүргүүлсэн.)*

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.1-д /мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;/, /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; /, 6 дугаар зүйлийн 6.4-т /Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ;/, 6.4.5-д /цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;/, 6.4.8-д /бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;/, 7.2 -т /Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй./ заасныг тус тус зөрчсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг зөрүүтэй тайлагнасан.	1	935.0	1	935.0	1	935.0	1	935.0				
Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг зөрүүтэй тайлагнасан.	1	1,065.5			1	1,065.5	1	1,065.5				
Халаалтын зардлын өглөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй.	1	1,631.9	1	1,631.9	1	1,631.9	1	1,631.9				
Дүн	3	3,632.4	2	2,566.9	3	3,632.4	3	3,632.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.	1	1501.5	1	1501.5							-		
Бараа материалыг шаардах хуудсаар олгоогүй, агуулахын бүртгэлийг хөтлөөгүйгээс бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан	1	-			1	-							
2022 онд хандив тусламжаар ирсэн "Ноос прэслэгч машин" болон "ноос хяргах цахилгаан хайч"-ыг орлого авч бүртгэл тайланд тусгаагүй.	1	-			1	-							
Хагас жилийн хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоог бодож баталгаажуулаагүй, байгууллагын эд хариуцагч солигдсон боловч хөрөнгө, өр төлбөр тооцооны тооллогыг хийгээгүй.	1				1	-					-		
Цалингийн зардлаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг ажил олгогчдоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлсөн.	1	92.4			1	92.4							
Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа 4 авто машинд зарцуулсан тээвэр шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй.	1	4,118.5			1	4,118.5							
Нийт дүн	6	5,712.4	1	1,501.5	5	4,210.9	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Аудитаар Засаг даргын Тамгын газрын дарга Н.Өлзийтогтох нь өмнөх аудитаар өгөгдсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулалттай холбоотой зөрчил арилгуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргаж хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй.	1	-									1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Албан хаагчидтай "Эд хөрөнгийн бүрэн хариуцлага"-ын гэрээг байгуулаагүй, ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл хөтлөөгүй.	1	-			1	-						

Тоног төхөөрөмжийн худалдан авалтыг тус бараа нь цахим дэлгүүрт байршсан эсэхэд судалгаа хийлгүй цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан.	1	29,280.0			1	29,280.0						
Сумын засаг даргын тамгын газрын нягтлан бодогч У.Сүнжидмаа нь жилийн эцсийн хөрөнгийн тооллогын явцад хяналт тавиагүй, тооцоог бодож баталгаажуулаагүй, тооллогын бүртгэлээрх хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд дахь хөрөнгийн үлдэгдлээс зөрүүтэй тайлагнаж зөрчлийг давтан гаргаж хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй	1	-							1	-		
Дүн	3	29,280.0	-	-	2	29,280.0	-	-	1	-	-	-
Нийт дүн	4	29,280.0	-	-	2	29,280.0	-	-	2	-	-	-